



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 02/03

Арвайхээр сум

“Хог хаягдлын менежментийг сайжруулах
стратеги төлөвлөгөө” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.14, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймгийн Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөө (2022-2030)-г хавсралтаар баталсугай.


2. Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөөтэй уялдуулан сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан төсөв санхүүг жил бүр аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүнс хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо (Д.Амартүвшин)-д үүрэг даалгасугай.

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2022-2030 он)

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Хууль эрх зүйн үндэслэл

Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын (2020-2024) оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр (2014-2022) он, Алсын хараа-2050, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Ногоон хөгжлийн бодлого, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (2014-2030), Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд хог хаягдлын талаар тусгагдсан зорилт арга хэмжээнүүдтэй уялдуулан уг стратеги төлөвлөгөөг боловсруулав.

1.2. Өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал

Өвөрхангай аймаг нь Засаг захиргааны 19 сум, 113 баг, 33700 өрх, 117 742 хүн амтай бөгөөд хүн амын өсөлт, хотжилт, бусад хүчин зүйлээс шалтгаалж аймаг, сумын хог хаягдлын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Аймаг, сумын төвийн хатуу хог хаягдлыг үр дүнтэй зохицуулах нь байгаль орчны тогтвортой байдал, хүн амын эрүүл мэндэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэтэл хог хаягдлыг ямар ч хяналт зохицуулалтгүйгээр эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулахуйц байдлаар байгальд булж, эсвэл ил задгай шатаасаар байгаа нь хүндрэлтэй асуудал болсоор байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд жилд дунджаар 40 гаруй мянган тонн хатуу хог хаягдал гарч байна. Аймаг, сумын төвүүдэд орон нутгийн өмчит хатуу хог хаягдлын менежментийн компани айл өрхүүд, төсвийн байгууллагууд, үйлдвэр аж ахуйн газрууд, бизнесийн байгууллагуудын ангилан ялгалт огт хийгдээгүй хог хаягдлыг цуглуулж тээвэрлэн хог хаягдлын цэгт шууд хаяж байна. Хэдийгээр хог хаягдлын талаас илүү хувь нь дахин боловсруулах боломжтой хуванцар, цаас, картон, шил, металл байдаг боловч ердөө 0.4%-ийг дахин ашиглаж, боловсруулж байна. Түүнчлэн аймаг, сумын төвийн төвлөрсөн хогийн цэг дээр хог түүдэг иргэд албан бусаар, ямар ч хяналт зохицуулалтгүй, аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй орчинд эрүүл мэндэд хор хөнөөл учруулахуйц байдлаар дахин боловсруулах хог хаягдлыг ангилан түүж байна.

Аймаг, сумын хатуу хог хаягдлын менежментэд хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, боловсруулах, зайлуулах технологи муу, дэд бүтэц, тоног тэхөөрөмж хангалтгүй, хог хаягдлын хэмжээ хурдацтай нэмэгдэж байгаа, хог хаягдлыг тогтмол бус цуглуулах, хууль бусаар байгальд хаяж зайлуулдаг нийгмийн үүрэг хариуцлагыг бэхжүүлэхэд чиглэсэн боловсролын компани ажил хийгддэггүй, хог хаягдлын тогтвортой менежментийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөлт байхгүй зэрэг бэрхшээлүүд тулгарч байна.

Иймд аймгийн хэмжээнд хог хаягдлын менежментийн дэд бүтцийг

байгуулах, тогтвортойгоор ажиллуулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, бохирдуулагч нь төлбөр төлөх, 3R (бууруулах, эргүүлэн ашиглан, дахин боловсруулах) зарчимд тулгуурлан иргэдийн сэтгэлгээг өөрчилж, ухамсрыг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлж бүх нийтийн оролцоотойгоор хамтдаа хог хаягдлыг бууруулж, цэвэр эрүүл орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

1.3. Стратеги төлөвлөгөөний хамрах хүрээ

1.3.1. Стратеги төлөвлөгөө нь хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа хамаарна.

ХОЁР. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

2.1.1. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөлт, удирдлага нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр (2014-2022), "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Ногоон хөгжлийн бодлого, Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (2014-2030), аймаг сумын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нягт уялдсан байна.

2.1.2. Стратеги төлөвлөгөөний зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ хог хаягдал үүсгэгч байгууллага, иргэн, айл өрх, төрийн ба төрийн бус байгууллагуудын хог хаягдлын нэгдсэн менежментийн талаарх ойлголт, түүнийг биелүүлэх хандлага, хамтын ажиллагаанд тулгуурлана.

2.1.3. Стратеги төлөвлөгөөг олон нийтэд ил тод, нээлттэй байлгаж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах, байгаль орчны бохирдлоос хамгаалахад чиглэсэн төсөл, хөтөлбөр арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.

2.2. Стратеги төлөвлөгөөний зорилго нь: Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, боловсруулах 3R цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулан хог хаягдлын дахин боловсруулах хэмжээг нэмэгдүүлэхэд оршино.

2.3. Энэхүү стратеги төлөвлөгөөний зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Зорилт-1. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах, хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, хог хаягдлын хяналт удирдлагын нэгдсэн цахим системтэй болох;

Зорилт-2. "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрийг дэмжин урамшуулах, байгаль орчинд хор нөлөөгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

Зорилт-3. Стандартын шаардлага хангасан ландфиллын байгууламжийг байгуулах, хуучин хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайн хэмжээг багасгах, хаах, нөхөн сэргээх үйл ажиллагааг төлөвлөх;

Зорилт-4. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах дадал хэвшлийг бий болгох, сургалт сурталчилгаа нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх системийг сайжруулах, дахин боловсруулах цэгийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих;

Зорилт-5. Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах, байгаль орчинд ээлтэйгээр түр хадгалах, саармагжуулж аюулгүй болгох, устгах зориулалтын байгууламжийг үе шаттайгаар байгуулах;

Зорилт-6. Эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, уул уурхай, аялал жуулчлалын бүс нутгийн хог хаягдлын менежментийг сайжруулах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх,

ГУРАВ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Стратеги төлөвлөгөөг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

I үе шат (2022-2025):

II үе шат (2026- 2030):

1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1. Хог хаягдлын мэдээллийн цахим сан бүрдүүлж, хог хаягдлын хэмжээ, урсгалыг байнгын хяналттай болгох, цахим систем хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх

2. Хог хаягдлын менежментийн тогтвортой санхүүжилтийн орчин, дэд бүтцийг сайжруулах

3. Сум бүр хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, энэ хүрээнд хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах, хог хаягдлыг хадгалах, цуглуулах, тээвэрлэлтийн зардлыг тооцож өртөг, үр ашиг хөрөнгө оруулалтын зардлын тооцооллыг гаргаж, үнийг бодит төвшинд барьж ажиллах

4. Төрийн зарим ажил, үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх түншлэлийн хүрээнд Өвөрхангай аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах ажлыг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, тэдэнд орон нутгийн төсөв болон төсөл хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах

5. Бохирдуулагч нь төлбөр төлөх зарчмыг дэмжиж, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх

6. Булаг шанд, голын эх ай сав, малын бэлчээр, уул овоо, төв суурин газрын хаалга орчмын болон гэрийн тэжээмэл амьтад (нохой муур) малын сэг зэмийн хог хаягдлын менежментийг сайжруулах

7. Хөдөөгийн айл өрхүүд өвөлжөө, хаваржаа, зусландаа ариун цэврийн байгууламжтай болох, ахуйн хог хаягдлаа устгах, төвлөрсөн хогийн цэгт хүргэж хаядаг хэвшлийг бий болгох

2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1. Хог хаягдлыг дахин боловсруулах, зам талбай, барилгын материал үйлдвэрлэх зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагааг дэмжих

2. Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах шийдлүүд, гадаад орны туршлагыг судалж, жижиг, дунд үйлдвэрийг туршин нэвтрүүлэх, боловсон хүчний чадавхийг сайжруулах

3. Хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэл бүхий хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй аргаар зайлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, хог хаягдлыг дахин боловсруулах, устгал хийх нөхцлийг бүрдүүлэх

4. Дахин боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, урамшууллын тогтолцоог бий болгох

3 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1. Аймаг, сум бүрт эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн цэг байгуулах, ашиглах;

2. Хуучин хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайн хэмжээг багасгах, хаах, нөхөн сэргээх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх,

4 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, татан зайлуулах дэд бүтцийн байгууламж, машин механизмын хүртээмжтэй байдлаар шийдэх, холбогдох заавар, аргачлал, стандартыг нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.Хог хаягдлын ангиллын систем, менежментийн тогтолцоонд монгол улсын стандартыг хэрэгжүүлэх, холбогдох журмыг мөрдөж ажиллах;

3.Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, зориулалтын уут сав хэрэглэх, хогийн цэгт хаях зэрэг дадал хэвшлийг төлөвшүүлэх, химийн бодисын зохистой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа зохион байгуулах, иргэдийн санал, санаачилгыг дэмжих;

4.Хог хаягдлыг ангилан бууруулах, амьдрах орчноо цэвэрлэж тохижуулах чиглэлээр орон нутгийн засаг захиргааны зүгээс нийтийг хамарсан ажлуудыг зохион байгуулах;

5.Эх үүсвэр дээр ангилсан дахивар бүтээгдэхүүнийг цуглуулах, тээвэрлэх системийг нэвтрүүлэх,

5 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.Аюултай хог хаягдлын талаарх хуулийн хэрэгжилтийг хангах менежментийн чадавхийг бэхжүүлж, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх;

2.Хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй импортын бараа, бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах;

3.Байгаль орчинд ээлтэйгээр аюултай хог хаягдлыг түр хадгалах, саармагжуулж аюулгүй болгох, устгах зориулалтын байгууламжийг үе шаттайгаар байгуулах,

6 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.Үйлдвэрийн хог хаягдлын менежментийг сайжруулах тогтолцоог бий болгох;

2.Бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг үйлдвэрлэгч эргүүлэн татаж ашиглах, дахин боловсруулах тогтолцоог дэмжих;

3.Нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар хог хаягдлыг бууруулах, хаягдалгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих;

4.Аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, орчны бохирдлыг бууруулах,

ДӨРӨВ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1.Стратеги төлөвлөгөө хэрэгжсэнээр хог хаягдлын зохистой менежментийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө хийгдэж, эх үүсвэр дээр хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшиж, хадгалах, цуглуулах, тээвэрлэх систем сайжран, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрийг дэмжин урамшуулж, хүний нөөцийн чадавх сайжирсан байна.

Нийт хог хаягдлын 30-аас доошгүй хувийг дахин боловсруулж, эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа жигдэрч, хуучин хогийн цэгийг төлөвлөгөөний дагуу хааж нөхөн сэргээж, хог хаягдлын хэмжээ багасна.

4.2.Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож, 2021 оны тоон мэдээллийг суурь болгон авч үзнэ:

Д/д	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь	Зорилтот түвшин	
			үзүүлэлт	2025 он	2030 он
			2021		
1	Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө	тоо	1	19	-
2	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	0.4	10	30
	Дахин боловсруулах үйлдвэрийг байгуулах	тоо	1	4	7
3	Эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн цэг	тоо	3	8	8
4	Аюултай хог хаягдлын саармагжуулж аюулгүй болгох, устгах зориулалтын байгууламж	тоо	3	6	10

ТАВ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- а. Улсын ба орон нутгийн төсөв
- б. Хог хаягдлын хураамж
- в. Олон улсын байгууллага, хандивлагчийн зээл, тусламж
- г. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
- д. Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын хөрөнгө оруулалт
- е. Бусад эх үүсвэр

ЗУРГАА. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

6.1. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын байгууллагаас стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, шинжилгээ, үнэлгээг явуулан хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

6.2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төслүүдийг аймаг, сумын Засаг дарга, Захирагчийн ажлын албанаас жил бүр аймаг, сумын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган, аймаг сумын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлж хэрэгжүүлнэ.

6.3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албанаас холбогдох газруудтай хамтран хариуцаж, үр дүнг жил тутам Аймаг, сумын Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнана.